



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорнод аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДОА-2020/88/СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Чойбалсан хот

2020 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга

бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас:70584203 Цахим хаяг: Bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: В.Цэнгэлмаа

Утас: 70584204 Цахим хаяг: Tsengelmaav@audit.gov.mn

Аудитор: С.Энхбаатар

Утас: 70584207 Цахим хаяг: Enkhbaatars@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ТШЗ	Төсвийн шууд захирагч
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ДОА	Дорнод аймаг



Аудитын гэрчилгээ	3
Аудитын тайлан.....	5
2.1. Оршил	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	7
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	7
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.12. Шилэн дансны мэдээлэл	9
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт.....	9
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	9
Менежментийн захидал.....	10
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан.....	11
4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	12
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	13
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	15
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	17
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	18



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2020.02.21 № 121

танай _____-ны № _____-т

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА Ц.МӨНХСАЙХАН ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Дорнод аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн Сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын Олон Улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Дорнод аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

110520042



Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн Сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ



2.1. Оршил

Дорнод аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг дарга Ц.Мөнхсайхан танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2019 оны 8 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорнод аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 13-наас 2020 оны 02 дугаар сарын 18-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 19-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, аудитор С.Энхбаатар хариуцаж хэрэгжүүлэв.

Дорнод аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 22-ний өдрийн 05/26 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Төрийн аудитын байгууллагаас



санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Дорнод аймаг дахь Шүүхийн тамгын газрын үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Шүүхийн үйлчилгээг үр нөлөөтэй бүтээмжтэй, хариуцлагатай хэрэгжүүлэхүйц чадварлаг захиргаа, дэд бүтцийг бүрдүүлж, ёс зүйн зөрчил гаргахгүй ажиллах”-д оршино.

Дорнод аймаг дахь Шүүхийн тамгын газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах, хамгаалах, шүүхийн зохион байгуулалт, захиргаа, хүний нөөцийг удирдах, тухайн шүүхийн төсвийг төлөвлөх, шүүхийн санхүү, дэд бүтцийг удирдах, шүүгчдийг мэдээллээр хангах, олон нийттэй харилцах чиг үүргийг хэрэгжүүлэх.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт гараагүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Дорнод аймаг дахь Шүүхийн тамгын газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Дархан цаазат газруудын Дорнод хамгаалалтын захиргаа нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Acolous программ хангамж ашигладаг байна.

Дорнод аймаг дахь Шүүхийн тамгын газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Дорнод аймаг дахь Шүүхийн тамгын газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 14 эрсдэлтэй асуудалд 14 горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.



2.7. МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “ дунд ” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 1,159,334.6 мянган төгрөгөөс тооцон 23,186.7 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд тайлант үеийн гүйцэтгэлээр материаллаг байдлын түвшинг 23,500.6 мянган төгрөгөөр тооцсон.

2.8. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Дорнод аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 54,065.9 мянган төгрөгөөр буюу 4.1 хувиар буурсан нь элэгдэлтэй холбоотой байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан данс байхгүй байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	00.0	00.0	00.0
Авлага	326.7	00.0	-326.7
Бараа материал	10,862.4	7,989.9	-2,872.5
Үндсэн хөрөнгө	1,690,217.3	1,687,049.9	-3,167.4
Үндсэн хөрөнгийн элэгдэл	-403,967.4	-451,666.8	-47,699.4
Нийт хөрөнгө	1,297,439.0	1,243,373.0	-54,066.0
Өр төлбөр	00.0	00.0	00.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,297,439.0	1,243,373.0	-54,066.0
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,297,439.0	1,243,373.0	-54,066.0

Бараа материалын дансны үлдэгдэл буурсан нь бичиг хэргийн материал акталснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл буурсан нь хөрөнгө акталснаас шалтгаалжээ. Тайлант онд ТӨБЗГ болон дээд газрын зөвшөөрлөөр 6,678.5 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга худалдан авсан, ТЕЗ-аас 4,254.1 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, ном үнэ төлбөргүй шилжүүлсэн дүнгээр нэмэгдэж, 14,100.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл акталсан дүнгээр буурсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,243,373.0 мянган төгрөг болж 54,066.0 мянган төгрөгөөр буурсан нь үйл ажиллагааны үр дүн буурснаас шалтгаалжээ. Энэ нь элэгдлийн зардлын дүн өндөр байгаатай холбоотой байна.



2.9. ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 8 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй. Тус байгууллагын хувьд орлогын төлөвлөгөө байхгүй байна.

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан 1,116,189.7 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 1,116,189.7 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 1,116,189.7 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөгджээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,105,261.1 мянган төгрөг буюу 99.0 хувьтай байгаа нь тайлант хугацаанд төсвийн хуваарийн дагуу зардлыг зарцуулсантай холбоотой байна.

2.10. АУДИТААР ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОРИМ СОРИЛ, ТҮҮНИЙ ҮР ДҮН

Аудитыг төлөвлөх үе шатанд 14 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 14 эрсдэл тодорхойлж, нийт 14 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 69,328.6 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 63,830.3 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 2 зөвлөмж өгч ажиллалаа. Үүнд:

1. Тайлант хугацаанд хийсэн бараа материалын 63,830.3 мянган төгрөгийн худалдан авалтын E-баримтыг анхан шатны баримтад хавсаргаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2-д “Аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг мөрдөх анхан шатны баримтын загвар, бүрдүүлэх аргачлалыг санхүү, бүртгэлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална”, Сангийн сайдын 2017 оны 345 дугаар тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын 6.5, Монгол Улсын стандарт MNS 6529:2015 “татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан тусгай нууцлалын QR кодоор баталгаажсан анхан шатны цаасан баримтуудыг бүрдүүлж ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч E баримтыг хавсаргах” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх.

Аудитаар илэрсэн 5,498.3 мянган төгрөгийн алдаа зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Байхгүй.



2.13. Шилэн дансны мэдээлэл

Дорнод аймаг дахь Шүүхийн тамгын газар Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1.4 сая төгрөгийн 3 төлбөрийн акт тогтоосныг бүрэн барагдуулж, 1 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

2.13. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Шүүхийн тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Дорнод аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 дугаар зүйл, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.



Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Худалдан авалтын талаар:

- 1.1. Илрүүлэлт: Нягтлан бодох бүртгэлийн ерөнхий журналд ажил гүйлгээг гарсан цаг хугацаагаар нь бүртгээгүй байна.
- 1.2. Эрсдэл: Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх.
- 1.3. Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх заалтыг мөрдөж ажиллах.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Өгсөн зөвлөмжийн дагуу ажиллах болно

2. МУЕА-аас өгсөн чиглэлийн дагуу суудлын автомашины ашиглалтын талаар

- 2.1. Илрүүлэлт: Тус байгууллагын шүүгч ажилтнууд нь дуудлагын автомашин хэрэглэхдээ холбогдох журамд заасан захиалгын хуудаст бүрэн үндэслээгүй, тодорхой ажлын гүйцэтгэлгүй байна.
- 2.2. Эрсдэл: Төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах.
- 2.3. Өгсөн зөвлөмж: Дуудлагын автомашин хэрэглэхдээ холбогдох хууль журмыг мөрдөж ажиллах байх.
- 2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Өгсөн зөвлөмжийг мөрдөж ажиллана.



Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

4.1 АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/төгрөгөөр/



Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>11,189,073.00</u>	<u>7,989,859.00</u>
33	АВЛАГА	326,713.00	00.00
335	Бусад авлага	326,713.00	00.00
3351	Байгууллагаас авах авлага	326,713.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	10,862,360.00	7,989,859.00
354	Хангамжийн материал	10,862,360.00	7,989,859.00
35410	Бичиг хэргийн материал	4,162,750.00	1,455,450.00
35420	Аж ахуйн материал	5,790,710.00	6,534,409.00
35430	Сэлбэг хэрэгсэл	00.00	00.00
35440	Түлш, шатах тослох материал	908,900.00	00.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,286,249,884.25</u>	<u>1,235,383,105.72</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,286,249,884.25	1,235,383,105.72
392	Биет хөрөнгө	1,143,349,884.25	1,092,483,105.72
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,046,250,169.52	1,046,250,169.52
39202	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-23,630,959.08
39203	Авто-тээврийн хэрэгсэл	182,036,000.00	167,936,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-160,313,777.90	-161,547,111.26
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	193,702,173.37	203,000,130.37
39206	Хуримтлагдсан элэгдэл	-171,490,171.25	-182,944,924.34
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	112,273,497.85	113,859,497.85
39208	Хуримтлагдсан элэгдэл	-71,613,424.29	-82,255,328.01
39214	Бусад үндсэн хөрөнгө	12,498,616.95	12,498,616.95
39215	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-738,446.28
39217	Ном	6,800.00	55,460.00
393	Биет бус хөрөнгө	142,900,000.00	142,900,000.00
39301	Програм хангамж	550,000.00	550,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-550,000.00	-550,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,297,438,957.25</u>	<u>1,243,372,964.72</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>00.00</u>	<u>00.00</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,297,438,957.25</u>	<u>1,243,372,964.72</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,297,438,957.25	1,243,372,964.72
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	880,290,972.00	880,290,972.00
51101	Өмч: - төрийн	880,290,972.00	880,290,972.00
512	Хуримтлагдсан үр дүн	-77,279,169.31	-128,046,481.84
51210	Өмнөх үеийн үр дүн	-77,279,169.31	-73,980,489.31
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-54,065,992.53
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	494,427,154.56	491,128,474.56
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,297,438,957.25</u>	<u>1,243,372,964.72</u>

4.2 АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл /төгрөгөөр/
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,103,349,409.95	1,120,963,567.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	16,100,009.95	4,773,867.00



120	Нийтлэг татварын бус орлого	16,100,009.95	4,773,867.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	15,773,296.95	4,752,567.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	15,773,296.95	4,752,567.00
120009	Бусад орлого	326,713.00	21,300.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,087,249,400.00	1,116,189,700.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,087,249,400.00	1,116,189,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,087,249,400.00	1,116,189,700.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,159,334,583.34	1,175,029,559.53
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,159,334,583.34	1,175,029,559.53
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,157,892,345.34	1,162,100,992.53
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	861,766,000.00	875,408,902.00
210101	Үндсэн цалин	586,502,987.00	632,245,502.00
210102	Нэмэгдэл	220,756,436.00	198,605,900.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	29,154,000.00	26,832,000.00
210104	Урамшуулал	25,352,577.00	17,725,500.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	104,962,101.00	110,509,900.00
210201	Тэтгэврийн даатгал	71,345,973.00	74,575,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	8,386,706.00	8,983,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,740,482.00	7,186,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,680,876.00	1,796,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	16,808,064.00	17,967,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	16,825,111.00	14,342,268.00
210301	Гэрэл, цахилгаан	4,985,431.00	4,977,931.00
210302	Түлш, халаалт	9,937,828.00	7,563,191.00
210303	Цэвэр, бохир ус	1,901,852.00	1,801,146.00
2104	Хангамж, бараа материалын зардал	62,876,169.00	59,922,292.00
210401	Бичиг хэрэг	17,333,967.00	22,184,380.00
210402	Тээвэр, шатахуун	21,779,600.00	25,897,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	9,566,448.00	6,940,287.00
210404	Ном, хэвлэл	600,000.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,694,287.00	4,900,225.00
210408	Бараа материал акталсны зардал	6,901,867.00	00.00
2105	Нормативт зардал	800,000.00	682,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	800,000.00	682,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	23,790,543.00	27,086,009.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,543,500.00	3,661,000.00
210604	Урсгал засвар	21,247,043.00	23,425,009.00
2107	Томилолт, зочны зардал	11,278,300.00	6,062,500.00
210702	Дотоод албан томилолт	11,278,300.00	6,062,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,296,823.00	6,287,726.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,614,823.00	4,369,226.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,249,000.00	1,249,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	109,800.00	109,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	236,500.00
210807	Газрын төлбөр	301,200.00	301,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	71,297,298.34	61,799,395.53
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	00.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,000,000.00	00.00



210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	69,297,298.34	61,799,395.53
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,442,238.00	12,928,567.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	00.00	2,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	2,000,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,442,238.00	10,928,567.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,442,238.00	10,928,567.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-55,985,173.39	-54,065,992.53
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	68,915,454.64	00.00
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	68,915,454.64	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-68,915,454.64	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-124,900,628.03	-54,065,992.53

4.3 АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,101,935,774.00	1,116,189,700.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	838,433.00	00.00
120	Нийтлэг татварын бус орлого	838,433.00	00.00
120009	Бусад орлого	838,433.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,101,097,341.00	1,116,189,700.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,087,249,400.00	1,116,189,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,087,249,400.00	1,116,189,700.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	13,847,941.00	00.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	13,847,941.00	00.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,097,785,984.00	1,109,511,200.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,097,785,984.00	1,109,511,200.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,082,495,805.00	1,096,582,633.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	861,766,000.00	875,082,189.00
210101	Үндсэн цалин	586,502,987.00	631,918,789.00
210102	Нэмэгдэл	220,756,436.00	198,605,900.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	29,154,000.00	26,832,000.00
210104	Урамшуулал	25,352,577.00	17,725,500.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	104,011,900.00	110,509,900.00
210201	Тэтгэврийн даатгал	70,741,300.00	74,575,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	8,317,600.00	8,983,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,654,100.00	7,186,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,663,600.00	1,796,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	16,635,300.00	17,967,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	16,825,111.00	14,342,268.00
210301	Гэрэл, цахилгаан	4,985,431.00	4,977,931.00
210302	Түлш, халаалт	9,937,828.00	7,563,191.00
210303	Цэвэр, бохир ус	1,901,852.00	1,801,146.00
2104	Хангамж, бараа материалын зардал	56,846,695.00	56,177,541.00
210401	Бичиг хэрэг	18,957,760.00	18,957,330.00
210402	Тээвэр, шатахуун	20,988,500.00	24,988,500.00



Шүүхийн тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	9,566,448.00	6,940,287.00
210404	Ном, хэвлэл	600,000.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,733,987.00	5,291,424.00
2105	Нормативт зардал	800,000.00	800,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	800,000.00	800,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	23,832,543.00	27,320,509.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,543,500.00	3,661,000.00
210604	Урсгал засвар	21,289,043.00	23,659,509.00
2107	Томилолт, зочны зардал	11,278,300.00	6,062,500.00
210702	Дотоод албан томилолт	11,278,300.00	6,062,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,296,823.00	6,287,726.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,614,823.00	4,369,226.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,249,000.00	1,249,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	109,800.00	109,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	236,500.00
210807	Газрын төлбөр	301,200.00	301,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,838,433.00	00.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	838,433.00	00.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,000,000.00	00.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	15,290,179.00	12,928,567.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	13,847,941.00	2,000,000.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	13,847,941.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	2,000,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,442,238.00	10,928,567.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,442,238.00	10,928,567.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>4,149,790.00</u>	<u>6,678,500.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	4,149,790.00	6,678,500.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,149,790.00	6,678,500.00
2200	Дотоод эх үүсвэрээр	4,149,790.00	6,678,500.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	4,149,790.00	6,678,500.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-4,149,790.00</u>	<u>-6,678,500.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00



4.4 АУДИТ ХИЙГДСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ, ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	/ төгрөгөөр /
						Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	737,390,972.00	68,150,800.00	47,621,458.72	00.00	853,163,230.72
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	737,390,972.00	68,150,800.00	47,621,458.72	00.00	853,163,230.72
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	426,276,354.56	00.00	00.00	426,276,354.56
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	142,900,000.00	00.00	00.00	00.00	142,900,000.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-124,900,628.03	00.00	-124,900,628.03
C08	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	880,290,972.00	494,427,154.56	-77,279,169.31	00.00	1,297,438,957.25
D01	2019 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	880,290,972.00	494,427,154.56	-77,279,169.31	00.00	1,297,438,957.25
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	3,298,680.00	00.00	3,298,680.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	880,290,972.00	494,427,154.56	-73,980,489.31	00.00	1,300,737,637.25
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-3,298,680.00	00.00	00.00	-3,298,680.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-54,065,992.53	00.00	-54,065,992.53
D09	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	880,290,972.00	491,128,474.56	-128,046,481.84	00.00	1,243,372,964.72

4.5 АУДИТ ХИЙГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,116,189,700.00	1,105,261,133.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,116,189,700.00	1,105,261,133.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,114,189,700.00	1,103,261,133.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	885,358,400.00	875,082,189.00
210101	Үндсэн цалин	643,682,000.00	631,918,789.00
210102	Нэмэгдэл	198,605,900.00	198,605,900.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	25,345,000.00	26,832,000.00
210104	Урамшуулал	17,725,500.00	17,725,500.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	110,509,900.00	110,509,900.00
210201	Тэтгэврийн даатгал	74,575,500.00	74,575,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	8,983,600.00	8,983,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,186,900.00	7,186,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,796,700.00	1,796,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	17,967,200.00	17,967,200.00



2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14,561,200.00	14,342,268.00
210301	Гэрэл, цахилгаан	4,950,500.00	4,977,931.00
210302	Түлш, халаалт	8,308,100.00	7,563,191.00
210303	Цэвэр, бохир ус	1,302,600.00	1,801,146.00
2104	Хангамж, бараа материалын зардал	56,246,700.00	56,177,541.00
210401	Бичиг хэрэг	18,958,200.00	18,957,330.00
210402	Тээвэр, шатахуун	24,988,500.00	24,988,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,000,000.00	6,940,287.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,300,000.00	5,291,424.00
2105	Нормативт зардал	800,000.00	800,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	800,000.00	800,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	34,000,000.00	33,999,009.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	11,000,000.00	7,544,600.00
210604	Урсгал засвар	23,000,000.00	26,454,409.00
2107	Томилолт, зочны зардал	6,284,300.00	6,062,500.00
210702	Дотоод албан томилолт	6,284,300.00	6,062,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,429,200.00	6,287,726.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,499,700.00	4,369,226.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,249,000.00	1,249,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	109,800.00	109,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	247,500.00	236,500.00
210807	Газрын төлбөр	301,200.00	301,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2000000.00	2000000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,000,000.00	2,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,000,000.00	2,000,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	00.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,116,189,700.00	1,116,189,700.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,116,189,700.00	1,116,189,700.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,116,189,700.00	1,116,189,700.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	43.00	41.00
620001	Удирдах ажилтан	05.00	05.00
620002	Гүйцэтгэх ажилтан	32.00	30.00
620003	Үйлчлэх ажилтан	06.00	06.00
620004	Гэрээт ажилтан	00.00	00.00